



МОНГОЛ УЛСЫН МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН
УЛСЫН БАЙЦААГЧИЙН АКТ
ЗАВХАН АЙМГИЙН
МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗАР

212800 Улиастай, Завхан аймаг
Утас/факс: 7046-37-02
www.inspection.gov.mn

ЦЭЦЭН-УУЛ СУМЫН БҮРЭН ДУНД
СУРГУУЛИЙН ЗАХИРГААНД

2015.09.15 № 07-07-027-28

Үйл ажиллагааг түр зогсоох тухай.

Цэцэн-Уул сумын бүрэн дунд сургуулийн захиргаанаас аймгийн МХГ-т гаргасан хүсэлтийн дагуу сумын төвд байршилтай тус сургуулийн А корпусын баруун талаас 2 дахь ангийн хучилтын модон дам нуруу өмхөрч бат бэхээ алдан хугарсан байдалд захирал Б.Дамбадорж болон холбогдох хүмүүсийг байлцуулан 2015 оны 09-р сарын 11 -ний өдөр шалгалт хийлээ.

Шалгалтаар дараах зөрчил илэрлээ

1. Хөрөнгө санхүүжилтийн эх үүсвэр дутагдалтайгаас шалтгаалан сургуулийн хичээлийн байрууд болон барилгын үндсэн хийц бүтээцүүдэд барилгын норм дүрэмд заагдсан хугацаанд их засвар хийгдээгүйгээс эвдрэл гэмтэл үүсч бат бэхээ алдан аваар осол гарах нөхцөл бүрдэж байгаа нь Барилгын тухай хуулийн 9-р зүйлийн 9.1.1 заалтыг,

2. Хичээлийн А корпусын баруун талаас 2 дахь ангийн хучилтын модон дам нуруу өмхөрч хугарсан тул түр тулаас хийсэн, цаашид осол аваар гарах нөхцөл үүссэн байгаа нь Барилгын тухай хуулийн 9-р зүйлийн 9.1.1 заалтыг тус тус зөрчиж байна.

Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10-р зүйлийн 10.9.7 дахь заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Цэцэн-Уул сумын бүрэн дунд сургуулийн хичээлийн А корпусын баруун талаас 2 дахь ангид 2015 оны 09-р сарын 14-ны өдрөөс илэрсэн зөрчлийг арилгах хүртэл хугацаанд сургалт хүмүүжлийн үйл ажиллагаа явуулахыг түр зогсоохоор акт тогтоов.

2. Улсын байцаагчийн шийдвэрийг хэрэгжүүлэн ажиллахыг Цэцэн-Уул сумын бүрэн дунд сургуулийн захирал Б.Дамбадоржид хариуцуулав.

2016022


Шалгуулагч нь улсын байцаагчийн актад гомдол гаргах эрхтэй болно.

БАРИЛГЫН ТЕХНИКИЙН ХЯНАЛТЫН

УЛСЫН БАЙЦААГЧ  Ж.ЦЭДЭН-ИШ

ТАНИЛЦАЖ ХҮЛЭЭН АВСАН

ЗАХИРАЛ



Б.ДАМБАДОРЖ